



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ 2018 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТ

АУДИТЫН КОД: САГ-2019/193/СТА-ТШЗ

Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1 Оршил.....	4
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчин.....	5
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл	8
2.8.2 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	
2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал...	9
2.10 Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11 Шилэн дансны мэдээлэл.....	10
2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3. Менежментийн захидал.....	12
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
(САГ-2019/193/СТА-ТШЗ)	



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.03.15 № 06/460
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Харилцаа холбооны зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Харилцаа холбооны зохицуулах хорооны 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга Г.Чинзориг Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн авлагын бүртгэл, байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголиан Бизнес Рейтинг Аудит ХХК нь Харилцаа холбооны зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Үндэсний аудитын газартай байгуулсан гурвалсан гэрээг үндэслэн аудит хийлээ.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон НББОУС, УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 1 дүгээр сарын 22-ноос 2019 оны 3 дугаар сарын 5-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Монголиан бизнес рейтинг аудит ХХК-ийн ерөнхий захирал Д.Түмэнжаргал, чанарын хяналтын менежер Р.Цанжидмаа, аудитор Д.Нямдорж, аудитор А.Мөнхцоож, аудиторовын туслах Ө.Рагчаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Монголиан Бизнес Рейтинг Аудит ХХК-д 2019 оны 2 дугаар сарын 04-ний өдрийн 01/182 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Харилцаа холбооны зохицуулах хорооны талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Харилцаа холбооны зохицуулах хороо нь “Монгол Улсын нийгэм, эдийн засаг, хүний хөгжлийг дэмжсэн харилцаа холбооны салбарын зохицуулалтын таатай орчинг бүрдүүлэхэд оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл, зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл: Өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгж, иргэн харилцаа холбооны зах зээлд үр ашигтай, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, тусгай зөвшөөрөл олгох, мэргэжлийн дүгнэлт шийдвэр гаргах гэж тодорхойлжээ.

Харилцаа холбооны зохицуулах хорооны үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Харилцаа холбооны зохицуулах хорооны удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2018 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Харилцаа холбооны тухай хууль
- Радио долгионы тухай хууль
- Шуудангийн тухай хууль
- Аж ахуйн, үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль
- Олон нийтийн радио, телевизийн тухай хууль
- Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал, “Эдийн засгийн ангилал батлах тухай” эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Тайлант онд байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчны томоохон шинэчлэлт өөрчлөлт гаргаагүй ба Нийгмийн даатгалын тухай хуульд нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд татварын хөнгөлөлтөд өөрчлөлт орсныг хэрэгжүүлж ажилласан байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Харилцаа холбооны зохицуулах хорооны одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Харилцаа холбооны зохицуулах хорооны санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

**Харилцаа холбооны зохицуулах хорооны 2018 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Харилцаа холбооны зохицуулах хороо нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ Санхүүгийн тооцоолох групп ХХК-ийн боловсруулсан нягтлан бодох бүртгэлийн "Acolous 3.0", "Payroll" програм хангамжуудыг ашигладаг байна.

Харилцаа холбооны зохицуулах хорооны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Харилцаа холбооны зохицуулах хорооны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 4 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төлөвлөлтийн шатанд 2018 оны эхний хагас жилийн нийт зардал 2,041.9 сая төгрөгийг сонгосон. Гүйцэтгэлийн шатанд орлого 8,478.5 сая, зардал 6,256.0 сая төгрөг болж өссөн. Иймд гүйцэтгэлийн шатанд суурь үзүүлэлтийн өсөлтийг харгалзан материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгов.

Нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь тус байгууллага нь өөрөө өөрийгөө санхүүжүүлдэг боловч улсын төсөвт орлого төвлөрүүлдэггүй, нийт орлого нь тайлант хугацааны үйл ажиллагааг төлөөлж чадахуйц суурь үзүүлэлт гэж үзсэнтэй холбоотой юм.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2018 оны нийт орлого 8,478.9 сая төгрөг бөгөөд түүний 2.0 хувь болох 169.6 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2.0 хувиар тооцсон нь тухайн байгууллагын аудитын чиглэлүүдэд үзүүлж болзошгүй эрсдэлийг харгалзан үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшнийг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 4 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцлоо.

2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитын явцад залруулга хийгдээгүй болно.

2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

№	Шийдэл	Тоо	Дүн	(сая төгрөгөөр) Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	48.7	
2	Албан шаардлага өгсөн	1	19.8	
	Дүн	4	68.5	

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.2.1.1 Балансын данстай холбоотой асуудал

Сахилгын шийтгэл буруу ногдуулж, ажилтныг ажлаас халсан нь шүүхийн шийдвэрээр тогтоогдож, ажилгүй байсан хугацааны 19.7 сая төгрөгийн нөхөн олговор, нийгмийн даатгалын шимтгэлийг байгууллагаас төлж, төрд хохирол учруулсан.

Энэ нь Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5-д “Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-д заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй” гэсэн заалтуудыг зөрчсөн ба хэмжилт, үнэлгээ, үнэн зөв байдал, эрх ба үүрэг зэрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2012 оны 73 дугаар тогтоолоор зохицуулалтын үйлчилгээний хөлсийг 10 дахин нэмэгдүүлсэн, Цахим төсөл боловсруулан “Тусгай зөвшөөрлийн бүртгэл, төлбөр тооцооны програм” 2013 оноос нэвтрүүлж, програмд тухайн үеийн хүчинтэй байгаа 2700 тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хамааралтай

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2018 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

зохицуулалтын үйлчилгээний төлбөрийг бүртгээгүй буюу түүхчилсэн тусгай зөвшөөрөл эзэмшигч нийт 4300 нэгжийг хамруулан бүртгэсэн нь найдваргүй авлага үүсэх нөхцөл болсон зэрэг анхаарал татахуйц асуудлууд байна.

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Харилцаа холбооны зохицуулах хорооны чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 6 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 6,860.4 сая төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 4,452.9 сая төгрөг буюу 64.9 хувьтай буюу 1,302.9 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан нь дараах зардлуудын хэмнэлтээс шалтгаалжээ. Үүнд: цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 511.8 сая, хангамж, бараа материалын зардал 71.4 сая, эд хогшил, урсгал засварын зардал 30.5 сая, томилолт, зочны зардал 84.6 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр 571.9 сая төгрөг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Орлогыг задалж үзвэл байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого 7,721.0 сая, бусад орлого 757.8 сая, нийт 8,478.9 сая төгрөгийн орлоготой байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Харилцаа холбооны зохицуулах хороо Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Шилэн дансны тухай хуульд заасны дагуу төрийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор гаргасан удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих тогтолцоог хуулийн дагуу хангасан талаарх мэдээллийг шалгаж үзэхэд хуульд заасан хугацаанд жил улирал, сар, тухай бүр оруулах мэдээллийг www.shilendans.gov.mn сайтад байршуулж, толилуулсан байна.

Харилцаа холбооны зохицуулах хороо нь шилэн дансны нэгдсэн цахим системд 2018 онд 20 төрлийн мэдээллийг жил, улирал, сар, тухай бүрийн давтамжтайгаар 125 удаа мэдээлэхээс 56 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 36 мэдээллийг хугацаа хожимдуулж, 33 мэдээллийг мэдээлээгүй байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 7.1 сая төгрөгийн хоёр зөвлөмж өгсөнөөс зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100.0 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Харилцаа холбооны зохицуулах хорооны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Харилцаа холбооны зохицуулах хорооны нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Балансын данстай холбоотой асуудал

3.1.1. Илрүүлэлт

Авлагын оны эхний үлдэгдэл 3,771.2 сая төгрөг байснаас эцэст 3,537.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй буюу 234.2 сая төгрөгөөр буурсан хэдий ч 2-6 жилийн насжилттай 2,704.2 сая төгрөгийн авлагатай байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчсөн ба хэмжилт, үнэн зөв байдал, үнэлгээ, эрх ба үүрэг зэрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

3.1.2. Эрсдэл

- Хууль тогтоомж, заавар журам зөрчигдөх
- Удирдлага болон шийдвэр гаргагчдыг буруу мэдээллээр хангах
- Найдваргүй авлага үүсэх

3.1.3. Өгсөн зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтыг хэрэгжүүлж, насжилт өндөртэй авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллах.

3.1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар (САГ-2019/193/СТА-ТШЗ)

Тус байгууллага асуудлын бүртгэлтэй танилцаж, зөвшөөрсөн хариу тайлбарыг 2019 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 01/322 дугаар бүхий албан бичиг ирүүлсэн.

3.2. Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой асуудал

3.2.1. Илрүүлэлт

Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын 2018 оны А/162 дугаар тушаалын 1.а-д Харилцаа холбооны зохицуулах хорооны ажилтан, албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх, ажлын үр дүнгээр урамшуулал олгох журмын 2.2 дахь заалтыг “Харилцаа холбооны зохицуулах хорооны ажилтан, албан хаагчдын ажлын үр дүнг сар тутам дүгнэх ба улирлын эцэст тухайн улирлын саруудын үнэлгээний арифметик дунджаар тооцоолж хүснэгт 1-ийн дагуу үндсэн цалингийн 150 хүртэлх хувиар урамшуулал олгоно. Ажилтан тухайн улиралд ээлжийн амралттай байсан бол улирлын үнэлгээг ажилласан саруудын үнэлгээний дунджаар тооцно” гэж заасан байна.

Энэ нь Харилцаа холбооны зохицуулах хорооны хөдөлмөрийн дотоод журмын 4.4.2-д "Батлагдсан тусгай журмын дагуу улирлын ажлын үр дүнгээр ажилтанд урамшуулал олгож болно" гэсэн заалтуудыг зөрчсөн ба хэмжилт, үнэн зөв байдал, үнэлгээ зэрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

3.2.2. Эрсдэл

- Хууль тогтоомж, заавар журам зөрчигдөх
- Удирдлага болон шийдвэр гаргагчдыг буруу мэдээллээр хангах

3.2.3. Өгсөн зөвлөмж

Үр дүнгийн урамшуулал олгох заавар, журмыг хууль, тогтоомжид нийцүүлж, шинэчилж, мөрдөж ажиллах.

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Тус байгууллага асуудлын бүртгэлтэй танилцаж, зөвшөөрсөн хариу тайлбарыг 2019 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 01/322 дугаар бүхий албан бичиг ирүүлсэн.

3.3. Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой асуудал

3.3.1. Илрүүлэлт

Харилцаа холбооны зохицуулах хорооны гишүүдийн хурлын хөлсийг Санхүүгийн үр дүнгийн тайланд ажиллагчидтай холбогдсон зардлаар бүртгэж, тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Монгол Улсын Ерөнхий сайдтай байгуулсан “Төсвийн шууд захирагч буюу Харилцаа холбооны

зохицуулах хорооны даргын 2018 оны үр дүнгийн гэрээ"-ний 2 дугаар зүйлийн 2.4.3-д "Хорооны хурлын зардал" гэсэн заалтуудыг зөрчсөн ба хэмжилт, үнэн зөв байдал, үнэлгээ зэрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

3.3.2. Эрсдэл

- Хууль тогтоомж, заавар журам зөрчигдөх
- Санхүүгийн тайлан буруу гарах
- Удирдлага болон шийдвэр гаргагчдыг буруу мэдээллээр хангах

3.3.3. Өгсөн зөвлөмж

Санхүүгийн програмд өөрчлөлт оруулж, Харилцаа холбооны зохицуулах хорооны гишүүдийн хурлын зардлыг батлагдсан төсвийн ангилалын дагуу бүртгэж тайлагнах.

3.3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Тус байгууллага асуудлын бүртгэлтэй танилцаж, зөвшөөрсөн хариу тайлбарыг 2019 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 01/322 дугаар бүхий албан бичиг ирүүлсэн.

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2018 оны 6 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2018 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	2017.12.31	2018.12.31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	12,526,606,289.11	15,995,225,167.08
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	8,717,334,478.76	12,150,843,982.81
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	8,717,334,478.76	12,150,843,982.81
3121	Төгрөг	8,715,361,100.71	12,145,899,053.06
31213	Арилжааны банк дахь харилцах	8,715,361,100.71	12,145,899,053.06
3122	Гадаад валют	1,973,378.05	4,944,929.75
31223	Арилжааны банк дахь харилцах	1,973,378.05	4,944,929.75
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
33	АВЛАГА	3,771,228,703.35	3,537,020,961.27
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	3,548,856,709.86	3,313,650,601.86
335	Бусад авлага	222,371,993.49	223,370,359.41
3351	Байгууллагаас авах авлага	40,811,547.26	39,001,376.98
3352	Хувь хүмүүсээс авах авлага	181,560,446.23	184,368,982.43
34	УРЬДЧИЛГАА	24,094,223.00	294,248,023.00
34600	Урьдчилж гарсан зардал	5,805,000.00	3,697,500.00
3471	Урьдчилгаа тооцоо	18,289,223.00	290,550,523.00
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	17,982,000.00	290,243,300.00
34713	Цалингийн урьдчилгаа	307,223.00	307,223.00
35	БАРАА МАТЕРИАЛ	13,948,884.00	13,112,200.00
354	Хангамжийн материал	13,948,884.00	13,112,200.00
35410	Бичиг хэргийн материал	3,422,444.00	2,796,400.00
35430	Сэлбэг хэрэгсэл	9,920,000.00	9,906,000.00
35470	Бусад хангамжийн материал	606,440.00	409,800.00
36	НӨӨЦИЙН БАРАА	-	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,154,741,412.07	6,111,854,246.84
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,154,741,412.07	6,111,854,246.84
392	Биет хөрөнгө	4,639,670,261.14	4,238,346,112.31
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,571,868,969.00	1,923,602,610.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(472,286,781.02)	-
39203	Авто-тээврийн хэрэгсэл	678,958,853.71	733,158,853.71
39204	Хуримтлагдсан элэгдэл	(545,772,742.60)	(569,464,409.09)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	5,388,531,794.54	5,550,865,417.24
39206	Хуримтлагдсан элэгдэл	(3,114,357,021.33)	(3,504,856,603.26)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	294,865,494.59	262,428,329.26
39208	Хуримтлагдсан элэгдэл	(162,138,305.75)	(157,388,085.55)
393	Биет бус хөрөнгө	515,071,150.93	1,873,508,134.53

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2018 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

39301	Програм хангамж	997,975,646.84	1,236,762,763.74
39302	Хуримтлагдсан элэгдэл	(482,904,495.91)	(772,731,629.21)
39303	Бусад биет бус хөрөнгө	-	1,409,477,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>17,681,347,701.18</u>	<u>22,107,079,413.92</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,649,933,651.65</u>	<u>2,570,186,732.16</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	<u>1,649,933,651.65</u>	<u>2,570,186,732.16</u>
413	Өглөг	<u>208,055,034.77</u>	<u>491,790,537.58</u>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		7,771,764.64
4136	Бусад өглөг	<u>208,055,034.77</u>	<u>484,018,772.94</u>
41361	Байгууллагад төлөх өглөг	166,754,874.91	398,315,342.94
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	41,002,587.10	85,703,430.00
41364	НДШ - ийн өглөг /ТӨҮГ/	297,572.76	-
414	Урьдчилж орсон орлого	<u>1,441,878,616.88</u>	<u>2,078,396,194.58</u>
41440	Бусад урьдчилж орсон орлого	1,441,878,616.88	2,078,396,194.58
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>16,031,414,049.53</u>	<u>19,536,892,681.76</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	<u>16,031,414,049.53</u>	<u>19,536,892,681.76</u>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,169,840,273.85	2,595,812,553.85
512	Хуримтлагдсан үр дүн	<u>14,746,942,007.29</u>	<u>16,708,955,739.90</u>
51210	Өмнөх үеийн үр дүн	11,972,207,252.30	14,485,392,661.76
51220	Тайлант үеийн үр дүн	2,774,734,754.99	2,223,563,078.14
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	114,631,768.39	232,124,388.01
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>17,681,347,701.18</u>	<u>22,107,079,413.92</u>

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2018 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	8,406,428,121.11	8,478,891,154.35
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,406,428,121.11	8,478,891,154.35
120	Нийтлэг татварын бус орлого	8,406,428,121.11	8,478,891,154.35
120002	Хүүгийн орлого	415,714,201.06	651,746,055.46
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,663,247,187.45	7,721,042,932.49
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос Санхүүжих	7,663,247,187.45	7,721,042,932.49
120009	Бусад орлого	327,466,732.60	106,102,166.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,631,247,148.18	5,977,541,574.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,631,247,148.18	5,977,541,574.07
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,373,124,152.49	5,615,499,232.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,280,589,225.08	2,389,309,805.01
210101	Үндсэн цалин	2,280,589,225.08	2,389,309,805.01
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх Шимтгэл	252,411,378.99	288,447,562.61
210201	Тэтгэврийн даатгал	160,968,120.08	192,865,087.07
210202	Тэтгэмжийн даатгал	22,660,993.27	24,101,895.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	18,604,089.04	19,108,428.71
210204	Ажилгүйдлийн даатгал	4,504,085.15	4,669,479.18
210205	Эрүүл мэндийн даатгал	45,674,091.45	47,702,671.77
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол Зардал	53,016,373.57	70,609,669.06
210301	Гэрэл, цахилгаан	47,697,633.57	45,392,299.06
210302	Түлш, халаалт	-	11,750,000.00
210304	Байрны түрээс	5,318,740.00	13,467,370.00
2104	Хангамж, бараа материалын зардал	190,409,330.57	167,058,697.20
210401	Бичиг хэрэг	29,106,838.00	20,003,636.00
210402	Тээвэр, шатахуун	41,645,056.92	49,454,949.46
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	56,220,557.65	44,869,986.54
210404	Ном, хэвлэл	42,498,260.00	25,537,422.20
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,175,498.00	10,643,302.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	15,763,120.00	16,549,401.00
2105	Нормативт зардал	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	41,933,391.00	36,263,630.00
2107	Томилолт, зочны зардал	203,484,451.64	216,263,754.31
210701	Гадаад албан томилолт	165,221,108.14	175,652,928.31
210702	Дотоод албан томилолт	31,782,234.00	35,646,933.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	6,481,109.50	4,963,893.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	861,705,725.76	989,844,994.33

**Харилцаа холбооны зохицуулах хорооны 2018 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	687,591,062.39	742,426,947.48
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	41,761,220.18	28,826,892.12
210803	Даатгалын үйлчилгээ	13,046,560.00	4,514,365.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,083,200.00	1,108,383.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	43,633,270.34	53,547,324.00
210807	Газрын төлбөр	16,616,148.52	16,272,400.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	991,297.02	950,745.77
210811	Ерөнхий ба удирдлагын зардал	56,982,967.31	117,458,135.54
210813	Бусад зардал /ТӨҮГ/	-	7,187,730.22
210814	ҮХХАТатвар	-	17,552,071.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,489,574,275.88	1,457,701,119.59
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,313,461.02	11,796,336.75
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,433,613.50	6,599,403.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	872,626,208.94	840,652,390.20
210904	Найдваргүй авлагын алдагдал	595,200,992.42	598,652,989.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	258,122,995.69	362,042,341.96
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	258,122,995.69	362,042,341.96
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, Урамшуулал	258,122,995.69	262,985,732.96
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	88,032,702.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		11,023,907.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	2,775,180,972.93	2,501,349,580.28
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	649,080.81
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз		649,080.81
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	446,217.94	278,435,582.96
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	446,217.94	252,604.49
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал		278,182,978.47
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-25)	(446,217.94)	277,786,502.15)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	2,774,734,754.99	2,223,563,078.13

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2018 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,169,840,273.85	114,631,768.39	11,972,207,252.30	16,031,414,049.53
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,169,840,273.85	114,631,768.39	11,972,207,252.30	16,031,414,049.53
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	2,774,734,754.99	2,774,734,754.99
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,169,840,273.85	114,631,768.39	14,746,942,007.29	16,031,414,049.53
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-261,549,345.53	-261,549,345.53
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,169,840,273.85	114,631,768.39	14,485,392,661.76	15,769,864,704.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	117,492,619.62
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	1,425,972,280.00		2,223,563,078.14	3,649,535,358.14
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,595,812,553.85	232,124,388.01	16,708,955,739.90	19,536,892,681.76

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2018 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	6,762,928,653.85	8,492,270,044.16
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,762,928,653.85	8,492,270,044.16
120	Нийтлэг татварын бус орлого	6,762,928,653.85	8,492,270,044.16
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,010,777,548.74	7,729,664,277.55
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,010,777,548.74	7,729,664,277.55
120009	Бусад орлого	752,151,105.11	762,605,766.61
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	4,188,229,611.32	4,452,904,065.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,188,229,611.32	4,452,904,065.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,940,162,176.32	4,083,233,163.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,244,448,866.62	2,340,819,194.57
210101	Үндсэн цалин	1,435,901,045.62	1,403,831,123.57
210102	Нэмэгдэл	130,736,084.00	164,536,050.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	87,107,000.00	87,136,200.00
210104	Урамшуулал	590,704,737.00	600,743,162.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	84,572,659.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	276,668,897.00	282,544,327.99
210201	Тэтгэврийн даатгал	184,445,931.33	188,362,885.33
210202	Тэтгэмжийн даатгал	23,714,476.88	23,545,360.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,539,767.50	18,836,288.53
210204	Ажилгүйдлийн даатгал	5,269,883.76	4,709,072.13
210205	Эрүүл мэндийн даатгал	52,698,837.53	47,090,721.33
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	58,821,373.57	65,029,669.06
210301	Гэрэл, цахилгаан	52,197,633.57	45,392,299.06
210302	Түлш, халаалт	-	7,215,000.00
210304	Байрны түрээс	6,623,740.00	12,422,370.00
2104	Хангамж, бараа материалын зардал	186,579,149.11	174,770,547.74
210401	Бичиг хэрэг	27,433,238.00	22,286,636.00
210402	Тээвэр, шатахуун	40,587,000.00	48,914,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	55,724,993.11	44,869,986.54
210404	Ном, хэвлэл	41,339,500.00	30,619,182.20
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,210,698.00	10,851,402.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	16,283,720.00	17,228,841.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	51,873,735.00	36,329,110.00
210604	Урсгал засвар	51,873,735.00	36,329,110.00
2107	Томилолт, зочны зардал	219,407,629.04	217,270,969.51
210701	Гадаад албан томилолт	180,954,320.54	177,329,956.51
210702	Дотоод албан томилолт	31,782,544.00	34,977,120.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	6,670,764.50	4,963,893.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	876,970,424.30	948,903,177.08

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2018 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	746,823,147.27	799,607,970.34
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	49,674,555.67	54,287,061.77
210803	Даатгалын үйлчилгээ	13,046,560.00	7,931,865.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,083,200.00	1,108,383.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	49,083,064.34	51,192,680.00
210807	Газрын төлбөр	16,272,400.00	16,272,400.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	987,497.02	950,745.77
210816	Татварын байгууллагад төлсөн	-	17,552,071.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,392,101.68	17,566,167.83
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,606,657.18	11,796,764.83
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,785,444.50	5,769,403.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	248,067,435.00	369,670,901.68
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	248,067,435.00	369,670,901.68
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	248,067,435.00	271,474,024.48
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	87,217,970.20
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	10,978,907.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>2,574,699,042.53</u>	<u>4,039,365,978.70</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	572,611,509.00	606,410,970.62
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	572,611,509.00	606,410,970.62
2200	Дотоод эх үүсвэрээр	572,611,509.00	606,410,970.62
221001	Их засвар	-	2,026,800.00
222001	Тоног төхөөрөмж	572,611,509.00	406,260,425.00
223001	Бусад хөрөнгө	-	198,123,745.62
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(572,611,509.00)</u>	<u>(606,410,970.62)</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	-	(554,495.97)
250001	Гадаад валютын ханшийн зөрүү	-	(554,495.97)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=====	<u>554,495.97</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	2,002,087,533.53	3,433,509,504.05
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,715,246,945.23	8,717,334,478.76
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,717,334,478.76	12,150,843,982.81

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,860,435,842.00	5,059,315,036.09	1,801,120,805.91	73.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,755,835,842.00	4,452,904,065.47	1,302,931,776.53	77.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,353,135,842.00	4,083,233,163.79	1,269,902,678.21	76.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,795,877,920.00	2,340,819,194.57	455,058,725.43	83.7
210101	Үндсэн цалин	1,669,804,140.00	1,403,831,123.57	265,973,016.43	84.1
210102	Нэмэгдэл	177,531,710.00	164,536,050.00	12,995,660.00	92.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	128,040,000.00	87,136,200.00	40,903,800.00	68.1
210104	Урамшуулал	820,502,070.00	600,743,162.00	219,758,908.00	73.2
210105	Гэрээт ажлын хөлс	-	84,572,659.00	(84,572,659.00)	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	339,306,950.00	282,544,327.99	56,762,622.01	83.3
210201	Тэтгэврийн даатгал	226,204,633.33	188,362,885.33	37,841,748.00	83.3
210202	Тэтгэмжийн даатгал	28,275,579.17	23,545,360.67	4,730,218.50	83.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	22,620,463.33	18,836,288.53	3,784,174.80	83.3
210204	Ажилгүйдлийн даатгал	5,655,115.83	4,709,072.13	946,043.70	83.3
210205	Эрүүл мэндийн даатгал	56,551,158.34	47,090,721.33	9,460,437.01	83.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	64,615,000.00	65,029,669.06	(414,669.06)	100.6
210301	Гэрэл, цахилгаан	46,915,000.00	45,392,299.06	1,522,700.94	96.8
210302	Түлш, халаалт	4,800,000.00	7,215,000.00	(2,415,000.00)	150.3
210304	Байрны түрээс	12,900,000.00	12,422,370.00	477,630.00	96.3
2104	Хангамж, бараа материалын зардал	246,154,452.00	174,770,547.74	71,383,904.26	71.0
210401	Бичиг хэрэг	38,882,000.00	22,286,636.00	16,595,364.00	57.3
210402	Тээвэр, шатахуун	54,125,452.00	48,914,500.00	5,210,952.00	90.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	71,760,000.00	44,869,986.54	26,890,013.46	62.5
210404	Ном, хэвлэл	49,800,000.00	30,619,182.20	19,180,817.80	61.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,500,000.00	10,851,402.00	(2,351,402.00)	127.7
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	23,087,000.00	17,228,841.00	5,858,159.00	74.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	66,859,000.00	36,329,110.00	30,529,890.00	54.3
210604	Урсгал засвар	66,859,000.00	36,329,110.00	30,529,890.00	54.3
2107	Томилолт, зочны зардал	301,893,000.00	217,270,969.51	84,622,030.49	72.0

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2018 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210701	Гадаад албан томилолт	195,483,000.00	177,329,956.51	18,153,043.49	90.7
210702	Дотоод албан томилолт	92,410,000.00	34,977,120.00	57,432,880.00	37.8
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	14,000,000.00	4,963,893.00	9,036,107.00	35.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,451,659,000.00	948,903,177.08	502,755,822.92	65.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,284,874,000.00	817,160,041.54	467,713,958.46	63.6
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох	56,500,000.00	54,287,061.77	2,212,938.23	96.1
210803	Даатгалын үйлчилгээ	8,085,000.00	7,931,865.00	153,135.00	98.1
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,200,000.00	1,108,383.00	91,617.00	92.4
210806	Мэдээлэл, ехнологийн үйлчилгээ	80,000,000.00	51,192,680.00	28,807,320.00	64.0
210807	Газрын төлбөр	18,000,000.00	16,272,400.00	1,727,600.00	90.4
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	3,000,000.00	950,745.77	2,049,254.23	31.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	86,770,520.00	17,566,167.84	69,204,352.16	20.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	47,920,000.00	11,796,764.84	36,123,235.16	24.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	38,850,520.00	5,769,403.00	33,081,117.00	14.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	402,700,000.00	369,670,901.68	33,029,098.32	91.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	402,700,000.00	369,670,901.68	33,029,098.32	91.8
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	292,500,000.00	271,474,024.48	21,025,975.52	92.8
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	95,000,000.00	87,217,970.20	7,782,029.80	91.8
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,200,000.00	10,978,907.00	4,221,093.00	72.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,104,600,000.00	606,410,970.62	498,189,029.38	54.9
2200	Дотоод эх үүсвэрээр	1,104,600,000.00	606,410,970.62	498,189,029.38	54.9
221001	Их засвар	-	2,026,800.00	(2,026,800.00)	-
222001	Тоног төхөөрөмж	693,550,000.00	406,260,425.00	287,289,575.00	58.5
223001	Бусад хөрөнгө	411,050,000.00	198,123,745.62	212,926,254.38	48.2
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛ ЭХ ЭХ ҮҮСВЭР	5,827,500,000.00	8,492,270,044.16	(2,664,770,044.16)	145.7
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,827,500,000.00	8,492,270,044.16	(2,664,770,044.16)	145.7
1200041	Үндсэн үйп жиллагааны орлогоос санхүүжих	5,250,000,000.00	7,729,664,277.55	(2,479,664,277.55)	147.2

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2018 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1200042	Туслах үйлчилгээний орлогоос санхүүжих	577,500,000.00	762,605,766.61	(185,105,766.61)	132.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,717,334,478.76	8,717,334,478.76	-	100.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,684,398,636.76	12,150,843,982.81	(4,466,445,346.05)	158.1
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	108.00	100.00	8.00	92.6
620001	Удирдах ажилтан	16.00	13.00	3.00	81.2
620002	Гүйцэтгэх ажилтан	67.00	62.00	5.00	92.5
620003	Үйлчлэх ажилтан	10.00	10.00	-	100.0
620004	Гэрээт ажилтан	15.00	15.00	-	100.0

1. ХАВСРАЛТ

5.1 Аудитын явцад илэрсэн алдаа зөрчилтний асуудлын нэгтгэл

Огноо:	Аудитын нэр:	Харилцаа холбооны зохицуулах хорооны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:
2019/03/15			САГ-2019/193/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:		Харилцаа холбооны зохицуулах хороо	Сая төгрөгөөр:

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл			Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Огноо	Дугаар	Албан тушаал	Овог нэр
А	3	4	5			9	10
1	Авлагын оны эхний үлдэгдэл 3,771,228.7 мянган төгрөг, тайлант хугацаанд 5,511,775.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, 5,745,983.1 мянган төгрөгөөр буурч, оны эцсийн үлдэгдэл 3,537,020.9 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдэл 234,207.8 мянган төгрөгөөр буурсан хэдий ч 2-6 жилийн насжилттай 2,704,256.5 мянган төгрөгийн авлагатай байна.	-	Зөвлөмж өгөх			Дарга Ерөнхий нягтлан бодогч	Г.Чинзориг Н.Халиунаа
2	Сахилгын шийтгэл буруу ногдуулж, ажилтныг ажлаас халсан нь шүүхийн шийдвэрээр тогтоогдож, ажилгүй байсан хугацааны 19,661.1 мянган төгрөгийн нөхөн олговор, нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төлж байгууллагад хохирол учруулсан.	19,661.1	Албан шаардлага өгөх			Дарга Ерөнхий нягтлан бодогч	Г.Чинзориг Н.Халиунаа
3	Харилцаа холбооны зохицуулах хорооны ажилтан, албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх, ажлын үр дүнгээр урамшуулал олгох журам нь Засгийн газрын тогтоол, Хөдөлмөрийн дотоод журамтай нийцээгүй.	-	Зөвлөмж өгөх			Дарга Ерөнхий нягтлан бодогч	Г.Чинзориг Н.Халиунаа
4	Харилцаа холбооны зохицуулах хорооны гишүүдийн хурлын хөлсийг Санхүүгийн үр дүнгийн тайланд ажиллагчидтай холбогдсон зардлаар бүртгэж, тайлагнасан	48,664.0	Зөвлөмж өгөх			Дарга Ерөнхий нягтлан бодогч	Г.Чинзориг Н.Халиунаа
ДҮН		68,325.1					

